



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтаар хийгдсэн, 4 нэрийн нийт 59,450,347,227.00 (тавин есөн тэрбум дөрвөн зуун тавин сая гурван зуун дөчин долоон мянга хоёр зуун хорин долоо) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Г.Ёндон болон хавсралтад заасан байгууллагын захирал, дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Байгууламжийн доорх газрыг хүлээн авсан байгууллагын нэр дээр шилжүүлэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007513
2-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн
03 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН,
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар	Хүлээн авч бүртгэх аймаг, төрийн өмчит байгууллага
1	110/35/10кВ-ын Хархорин дэд станцын 110кВ-ын систем шинд хүчдэл тохируулгын төхөөрөмж	2023-08-21	6,701,559,904.00	16/2023	"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК
2	110/35/10кВ-ын Хархорин дэд станцын 110кВ-ын систем шинд хүчдэл тохируулгын төхөөрөмж	2023-08-21	202,423,395.00	16/2023	"Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК
3	Уурхайчин-1 хорооллын дэд бүтцийн ажил	2021-05-05 2022-01-10 2021-10-15	4,012,230,557.00	08/2021, 34/2021, 27/2021, 28/2021	Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
4	Уурхайчин-2, 3 орон сууцны хороолол хүртэлх дэд бүтцийн ажил	2023-07-20	48,534,133,371.00	16/2023А, 16/2023Б	Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
	НИЙТ ДҮН		59,450,347,227.00 (тавин есөн тэрбум дөрвөн зуун тавин сая гурван зуун дөчин долоон мянга хоёр зуун хорин долоон төгрөг)		